

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 5 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 147

Улаанбаатар хот

Г Хорооны 2008 оны 169 дүгээр тогтоолын 7
хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны “Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 169 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээ”-ний “Гадаад валютын арилжаа” гэсэн 4 дүгээр мөрний “50.0” гэснийг “100.0” гэж өөрчилсүгэй.

2. Гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй банк бус санхүүгийн байгууллагууд болон тус тогтоолыг гарахаас өмнө банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтээ ирүүлсэн хуулийн этгээдэд 2011 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор дүрмийн сангийн доод хэмжээгээ энэ тогтоолд заасан хэмжээнд хүргэхийг Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлэгчид, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

3. Хавсралтад өөрчлөлт оруулж олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН